

БАТАЛСАН:  
ЗАХИРАЛ..... С.БАЯСГАЛАН

УВС АЙМАГ ДАВСТ СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

Огноо:2024.05.16

СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРНЫ ХҮҮХДИЙН  
ХООЛНЫ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалт: **Дотуур байр бараа бүтээгдэхүүн нийлүүлэх**  
Гэрээний нэр, дугаар: **Дотуур байр : УВАДСЕБС20240201004**

Зүүнхөвөө  
2024

БАТЛАВ:

ЗАХИРАЛ:

С.БАЯСГАЛАН

Увс аймгийн Давст сумын ЕБС-ийн Дотуур байрны хүүхдийн хоолны  
материал нийлүүлэх тендерийн тооцоо

Д\д	Багцын код	Багц тендерийн нэр	Төсөвт өртөг
1	Багц-1	Мах	6.565.000
2	Багц-2	Хүнсний ногоо	1.845.000
3	Багц-3	Бусад, хуурай хүнс, Кг-ын бүтээгдэхүүн	8.314.670
4	Багц-4	ЖИМС, жимсгэнэ	1.895.150
5	Багц-5	Гурил	1045.000
6	Багц-6	Сүү, сүүн бүтээгдэхүүн	890.000
		Нийт	20.554.820

Тооцоо гаргасан нярав

Ч.ТУВААН

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо 2024-05-16

Тендер шалгаруулалтын нэр: Сургуулийн дотуур байрны хүүхдийн хоол

Тендер шалгаруулалтын дугаар: Сургуулийн дотуур байрны хүүхдийн хоол нийлүүлэх

Увс аймаг Давст сумын Ерөнхий боловсролын сургууль эрх бүхий тендерт оролцогчдоос сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны материал нийлүүлэх битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

**Төсөвт өртөг: 20.554.820**

### Дотуур байрны хүүхдийн хоолонд:

Нэгдүгээр багц: Мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх

Хоёрдугаар багц : Төмс, хүнсний ногоо

Гуравдугаар багц: Бусад, хуурай хүнсний бүтээгдэхүүн

Дөрөвдүгээр багц: Жимс, жимсгэний бүтээгдэхүүн

Тавдугаар багц: Гурил, гурилан бүтээгдэхүүн

Зургаадугаар багц: Сүү, сүүн бүтээгдэхүүн

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) цахимаар эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь Төрийн сан дахь нэмэлт санхүүжүүлэлтийн данс 100150315160 тоот дансанд 30000 төгрөгийг тушааж худалдан авч болно.

Борлуулалтын хэмжээ: Шаардахгүй.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Шаардахгүй.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2022 оны аудитаар баталгаажуулсан тайлан, 2023 оны жил эцсийн санхүүгийн тайлан

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Тендерийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 09.00 цагаас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлэх

Тендерийг 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 10.00 цагаас нээнэ. Хөтөлбөрт хамрагдах сурагчийн тоо: 49

Жич: Тендерт оролцох иргэн, аж ахуй нэгжүүд материал, үнийн саналаа тус тусад нь цахим хаягаар илгээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичгийг болон бусад мэдээллийг доорхи хаягаар авч болно.

Давст сумын Ерөнхий боловсролын ня-бо, нийгмийн ажилтан

Холбоо барих утас: 88849597, 99454138

## ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

### A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

#### 1. Тендерийн цар хүрээ

1.1. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (цаашид ТШӨХ гэж товчлох)-д тодорхойлсон захиалагч (цаашид “захиалагч” гэх) нь энэ тендерийн баримт бичгийн ТШӨХ болон техникийн тодорхойлолтод заасан бараа, материал болон тоног төхөөрөмж (цаашид “бараа” гэх) худалдан авах тухай гэрээ байгуулахаар энэхүү тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна.

1.2. Тендер шалгаруулалт нь ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд нэг багцтай байна.

1.3. Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн барааг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанд, газарт хүргэх үүрэгтэй.

#### 2. Санхүүжилтийн эх үүсвэр

2.1. Захиалагч дээр дурдсан барааг ТШӨХ-д тодорхойлсон эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

#### 3. Залилан мэхлэх болон авлигын үйлдэл

3.1. Төрийн албан хаагч болон тендерт оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч бүр худалдан авах ажиллагаанд оролцож гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.

3.2. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч нь Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигат, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлан сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй.

#### 4. Эрх бүхий тендерт оролцогч

4.1. Тендерийн урилга нь сонирхсон этгээд бүрт нээлттэй. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч болон түүний түншлэлийн гишүүн бүр нь аль ч улсын харьялалтай байж болно.

4.2. Дараах тохиолдолд тендерт оролцогч (түншлэлийн гишүүн бүрт нэгэн адил хамаарна)-ийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:

4.2.1. Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа; 4.2.2. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;

4.2.3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь бүтэц, зохион байгуулалт болон санхүүгийн хувьд захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг бол;

4.2.4. Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон;

4.2.5. Тендерт оролцогч (туслан гүйцэтгэг бүрийг оролцуулан) нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;

4.2.6. Илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг эрх бүхий байгууллага тогтоосон;

4.2.7. Сүүлийн 3 жилийн хугацаанд Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигын, залилан мэхлэх, зохиомол

тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон;

4.2.8. Энэхүү тендер шалгаруулалтад оролцож байгаа хоёр буюу түүнээс дээш тооны тендерт оролцогчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;

4.2.9. Энэхүү тендерийн баримт бичгийн ТОӨЗ-ны 14 дүгээр зүйлд хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тендерт оролцогч нэгээс дээш тендер ирүүлсэн бол; (Гэвч энэхүү заалт нь аливаа этгээдийг нэгээс дээш тендерт туслан гүйцэтгэгчээр оролцохыг, эсхүл нэг тендер шалгаруулалтад нэгээс олон багцад тендер ирүүлэхийг хязгаарлахгүй)

4.3. Тендерт оролцогч 4.2.1 - 4.2.9-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.

### 5.Эрх бүхий бараа

5.1. Гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно. Захиалагч төлбөрийг зөвхөн ТОГЗ-ны 1.1-д дурдсан барааг хүлээн авснаар төлнэ.

5.2. Энэхүү зааварчилгааны 5.1-д дурдсан барааны гарал үүсэл гэдэгт тухайн барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн улс орон буюу газар нутгийг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.

### 6.Түншлэл

6.1. Хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендерт оролцогч /цаашид талуудыг хамтад нь “түншлэл”, тус бүрийг нь “түншлэлийн гишүүн” гэх/ болж тендер ирүүлэх тохиолдолд ТШГХ-дөөрөөр заагаагүй бол дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

(а) түншлэлийн бүх гишүүний хувьд тендер хүчин төгөлдөр байхаар тендерт гарын үсэг зурсан байх;

(б)ТОГЗ-ны 1.1-д заасан бараа нийлүүлэх гэрээг хэрэгжүүлэхэд бүх гишүүн хамтран болон тус тусдаа хүлээх хариуцлагыг тодорхойлж хамтран ажиллах гэрээнд тодорхойлсон байх;

(в) түншлэлийн аль нэг болон бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авахад тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилох;

(г) нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөр тооцоог зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй харилцаж, гүйцэтгэх тухай хамтран ажиллах гэрээгээр зохицуулсан байх;

(д)түншлэлийн гэрээний хувийг тендерийн хамт ирүүлэх.

## Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

### 7.Тендерийн баримт бичгийн агуулга

7.1. Тендерийн баримт бичиг нь дор дурдсан бүлгүүдийг агуулсан 3 хэсэг баримт бичиг болон ТОГЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу хийсэн нэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ. Үүнд: I хэсэг

Бүлэг 1. Тендерт оролцогчид өгөх зааварчилгаа

Бүлэг 2. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт

Бүлэг 3 Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт

Бүлэг 4. Тендер шалгаруулалтын маягт

• Тендерийн маягт

• Үнийн хуваарь

• Тендерийн баталгааны маягт

• үйлдвэрлэгч /гэрээт борлуулагчийн зөвшөөрлийн маягт II хэсэг

Бүлэг 5. Бараа нийлүүлэлтэд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолт III хэсэг

Бүлэг 6. Гэрээний ерөнхий нөхцөл

Бүлэг 7. Гэрээний тусгай нөхцөл

Бүлэг 8. Гэрээний маягт •

Гэрээний маягт •

Гүйцэтгэлийн баталгааны маягт

• Урьдчилгаа төлбөрийн баталгааны маягт

Хавсралт: Тендериин урилга

7.2. Захиалагчийн нийтэлсэн тендерийн урилга нь тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

7.3. Тендерт оролцогч тендерийн баримт бичиг дэх бүх зааварчилгаа, нөхцөл, маягт болон техникийн тодорхойлолтыг нягталж үзэх нь зүйтэй. Тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлэхгүй байх, маягтыг дутуу бөглөн ирүүлэх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болж болно. Бараа нийлүүлэх тендерийн жишиг баримт бичиг

### **8. Тендерийн баримт бичгийг тодруулах**

8.1. Тендерт оролцохыг сонирхогч нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоо ("утсан холбоо"-нд зөвхөн телекс болон факсыг хамруулна)-гоор ТШГХ-дзаасан захиалагчийн хаягаар ирүүлнэ. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ТШГХ-д заасан хоногийн өмнө хүлээн авсан хүсэлтэд хариу өгнө. Хүсэлтийн агуулга, түүнд өгөх захиалагчийн хариуг хүсэлтийн эх сурвалжийг дурдалгүйгээр тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ.

8.2. Тухайн тодруулгын үр дүнд захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл энэхүү ТОГЗ-ны 9дүгээр зүйл, 24.2 дахь хэсэгт заасан журмыг баримтална.

### **9. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах**

9.1. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно.

9.2. Ийнхүү оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ. Тендерт оролцогч нэмэлт тус өөрчлөлт бүрийг хүлээн авсан тухайгаа захиалагчид утсан холбоогоор мэдэгдэх үүрэгтэй.

9.3. Тендерийн баримт бичигт орсон нэмэлт, өөрчлөлтийн улмаас тендер зайлшгүй өөрчлөгдөх ба уг өөрчлөлтийг бэлтгэхэд шаардлагдах хангалттай хугацаа тендерт оролцогчид олгох шаардлагатай гэж үзвэл захиалагч 24.2-т заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгаж болно.

## **В. ТЕНДЕРТ БЭЛТГЭХ**

10. Тендер шалгаруулалтад оролцох зардал

10.1. Тендерт оролцогч тендер бэлтгэх, захиалагчид ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө бүрэн хариуцах бөгөөд захиалагч ямар ч нөхцөлд энэхүү зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.

### **11. Тендерийн хэл**

11.1. Тендер, түүнчлэн тендертэй холбоотойгоор захиалагч тендерт оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захидалтууд болон бусад баримт материалыг тендерт оролцогчид өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх баримт бичиг нь монгол хэл дээр, гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол тэдгээр нь ТШГХ-д заасан хэл дээр байна. Тендерийн баримт бичгийн монгол хэл дээрх хувь гадаад хэл дээрхтэй зөрчилдвэл монгол хэл дээр бэлтгэсэн ТББ-ийн заалтыг баримтална.

11.2. Аливаа тендерийг дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн тендерт холбогдох хэсгийг ТОГЗ-ны 11.1-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг тендерт оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг тендерийг хянан үзэх, үнэлэхэд харгалзана. Бараа нийлүүлэх тендерийн жишиг баримт бичиг 7

## 12. Тендерийн иж бүрдэл

12.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ.

Үүнд: (а)ТОГЗ-ны 13, 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн тендерийн маягт болон үнийн хуваарь;

(б)захиалагч шаардсан бол ТОГЗ-ны 21 дүгээр зүйлд заасны дагуу ирүүлэх тендерийн баталгаа;

(в) тендерт оролцогчийг төлөөлж ТОГЗ-ны 22 дугаар зүйлд заасны дагуу тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийг баталгаажуулж гаргасан итгэмжлэл;

(г) тендерт оролцогчийг тухайн тендерт оролцох эрх бүхий гэдгийг тогтооход шаардлагатай ТОГЗ-ны 17 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;

(д)тендерт оролцогч нь тухайн гэрээг хэрэгжүүлэх чадвартай болохыг тогтооход шаардлагатай ТОГЗ-ны 18 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;

(е)нийллэх бараа болон түүнийг дагалдах үйлчилгээ нь тендерийн баримт бичигт нийцэж буйг баталгаажуулсан ТОГЗ-ны 19 дүгээр зүйлд заасан нотлох баримт;

(ё)ТШГХ-д шаардсан ТОГЗ-ны дагуу бэлтгэж ирүүлэх бусад материал.

## 13. Тендерийн маягт болон үнийн хуваарь

13.1. Тендерт оролцогч нь Бүлэг 4-т заасан тендерийн маягтыг бөглөж ирүүлнэ. Энэхүү маягтыг бөглөхдөө түүний агуулгыг өөрчлөлгүйгээр түүнд шаардсан бүх мэдээллийг тусгана.

13.2. Тендерт оролцогч нь нийлүүлэх бараа болон түүнийг дагалдах үйлчилгээний үнийн хуваарийг бэлтгэн ирүүлнэ. Үнийн хуваарийг 4 дүгээр бүлэгт заасан тендер шалгаруулалтын маягтаас тохирох маягтыг ашиглан бэлтгэнэ.

## 14. Хувилбарт тендер

14.1. ТШГХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн зөвхөн нэг тендер ирүүлэх ба хувилбарт тендер ирүүлэхийг үл зөвшөөрнө.

## 15. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт

15.1. Тендерийн маягт болон үнийн хуваарь дахь тендерт оролцогчийн санал болгож буй үнэ болон, үнийн хөнгөлөлт нь дор тодорхойлсон шаардлагад нийцсэн байна.

15.2. Үнийн хуваарыт бүх багц болон нэр төрлийг үнэ тус бүрээр нь тусад нь жагсааж ирүүлнэ.

15.3. Тендерийн маягтад тусгасан үнэ нь аливаа үнийн хөнгөлөлтийг тооцоогүй тухайн тендерийн нийт үнэ байна.

15.4. Тендерт оролцогч нь аливаа нөхцөлт бус үнийн хөнгөлөлт болон түүнийг хэрэглэх аргачлалыг тендер ирүүлэх маягтад тусад нь тусгасан байна.

15.5. Олон улсын худалдааны EXW, CIP болон ижил төстэй бусад нөхцөлийг хэрэглэхдээ ТШГХ-д дурдсан, Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргасан Incoterms-ийн хамгийн сүүлийн хувилбарыг удирдлага болгоно.

15.6. Нийлүүлэх барааны үнийг тендерийн маягт (Бүлэг 4)-д заасан үнийн хуваарь бүрээр гаргаж ирүүлнэ. Ингэхдээ тендерт оролцогч нь гэрээний дагуу нийлүүлэх барааны нэгж үнэ, тухайн нэр төрлийн нийт үнэ, нийт дүн, барааны гарал үүслийн улсын нэрийг бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан нэр төрөл бүрээр холбогдох үнийн хуваарыт тусгаж ирүүлнэ. Үнийн задаргааны агуулга нь захиалагчаас тендерийг харьцуулж үнэлэх зорилгоор шаардагдана. Энэ нь санал болгосон аливаа нөхцөлөөр гэрээ байгуулах захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.

15.7. Бараа нийлүүлэх тендерийн жишиг баримт бичиг

15.8. Барааг багцалсан эсэх талаарх мэдээллийг ТОГЗ-ны 1.2 дахь заалт болон түүнд харгалзах ТШГХ-ийн заалтаас үзнэ үү. Хэрэв багцалсан бол тендерт оролцогч нэг, эсхүл түүнээс олон багцад тендер ирүүлэх эрхтэй. Аливаа багцыг хувааж дэд багц болгон тендер ирүүлэхийг хориглоно.

15.9. Үнийн хуваарьт дараах зүйлсийг тусад нь бичиж харуулна. Үүнд:

**(а) Монгол Улсад үйлдвэрлэгдсэн барааны хувьд:**

1. барааны EXW үнэ (үйлдвэрийн, агуулахын, эсхүл лангууны үнийн аль тохирохыг). Энэ үнэд барааг үйлдвэрлэх, угсрехад ашигласан үйлдвэрийн, эсхүл лангууны үнээр үнэлэгдсэн эд анги, түүхий эд, үйлдвэрлэлийн бусад өртөг багтана;

2. гэрээ байгуулах эрх олгогдсоноор дотоодын бүтээгдэхүүнд ногдуулдаг нэмэгдсэн өртгийн болон бусад адилтгах албан татвар;

3. барааг ТШГХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардлагатай хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.

**(б) Монгол Улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд импортоор орж ирэх барааны хувьд:**

1. ТШГХ-д захиалагчийн нэрлэсэн хилийн боомт хүртэлх СИФ/CIF/ үнэ, эсхүл захиалагчийн нутаг дэвсгэр дэхь нэрлэсэн байрлал хүртэлх СИП /CIP/ үнэ;

2. гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирэх бараанд ногдох гаалийн, нэмэгдсэн өртгийн болон бусад албан татвар;

3. барааг орох боомтоос буюу нэрлэсэн байрлалаас ТШГХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардагдах хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.

**(в) Монгол Улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд өмнө нь импортоор орж ирсэн барааны хувьд:**

1. Барааны үнэ буюу импортоор анх орж ирсэн тухайн барааны үнэ дээр үнийн нэмэгдэл/эсхүл хөнгөлөлт/, дотоодод гарсан аливаа нэмэлт өртөг, тухайн бараанд төлсөн эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татваруудыг тооцсон үнэ;

2. Импортлогдсон бараанд урьд төлсөн(нотлох баримтыг хамт ирүүлэх шаардлагатай), эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татварууд;

3. Тухайн барааг олж авахад зарцуулсан өртөг буюу энэ заалтын 1 болон 2 ын ялгавар;

4. Гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирсэн бараанд ногдох нэмэгдсэн өртгийн болон бусад албан татвар;

5. Барааг ТШГХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардлагатай хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.

(г) Барааны Техникийн тодорхойлолт болон холбогдох үйлчилгээний талаарх шаардлагад тодорхойлсон Дагалдах үйлчилгээний хувьд: Гэрээ байгуулах эрх олгогдсоноор Дагалдах үйлчилгээнд ногдох Худалдан авагч орны гаалийн, худалдааны болон бусад адилтгах албан татварыг тооцож (1)Дагалдах үйлчилгээг бүрдүүлж буй зүйл тус бүрийн дотоодын валютаар илэрхийлэгдэх зардлын өртөг; (2)Дагалдах үйлчилгээг бүрдүүлж буй зүйл тус бүрийн гадаадын валютаар илэрхийлэгдэх зардлын өртгийг тус тус харуулна. Бараа нийлүүлэх тендерийн жишиг баримт бичиг 9

15.10. ТШГХ-д гэрээний үнийг тохируулах нөхцөлтэй байхаар тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байна. Тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулж өөрчлөхөөр санал болгосон аливаа тендерийг ТОГЗ-ны 31 дүгээр зүйлд заасны дагуу үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж, уг тендерээс татгалзана. Гэвч ТШГХ-д үнэ тохируулахаар заасан нөхцөлд тогтмол үнэ санал болгосон тендерээс татгалзахгүй бөгөөд түүний үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэг (0)-тэй тэнцүү байна гэж үзнэ.

15.11. ТШГХ-д үнэ тохируулахаар заасан бол үнэ тохируулах нөхцөл, аргачлалыг гэрээний тусгай нөхцөлд тусгана.

15.12. Гэрээний үнэ нь запруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

16. Тендерийн валют

16.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь хэсэгт заасны дагуу тендерийн үндсэн валют нь төгрөг байна.

17. Тендерт оролцогч эрх бүхий эсэхийг нотлох баримт

17.1. Тендерт оролцогч нь эрх бүхий эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтад үндэслэн тогтооно. Үүнд:

(а) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар,

(б)тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл;

(в)ТШГХ-д шаардсан бол тухайн төрлийн бараа нийлүүлэх тусгай зөвшөөрөл.

## 18. Тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт

18.1. Тендерт оролцогч нь гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан захиалгчийн шаардсан чадварын шаардлагыг хангасан гэдгийг харуулах дараах мэдээллийг нотлох баримт болгон ирүүлнэ. Үүнд:

(а) хэрэв ТШГХ-д шаардсан бол тендерт оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг тендерт санал болгох тохиолдолд уг барааг Монгол Улсад нийлүүлэх эрх олгосон тухай үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг 4 дүгээр бүлгийн маягтаас тохирох маягтыг ашиглан ирүүлнэ;

(б)санхүүгийн чадавхийг харуулах ТШӨХ-д заасан тоо бүхий жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан;

(в)гэрээг хэрэгжүүлэх удирдах болон техникийн голлох боловсон хүчиний чадвар, туршлагын талаарх мэдээлэл;

(г) тухайн тендерт оролцогчийн туршлагыг харуулах сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний талаарх мэдээлэл;

(д)хэрэв ТШӨХ-д шаардсан бол Монгол Улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй тендерт оролцогч гэрээний дагуу хийгдэх засвар үйлчилгээ, техникийн тодорхойлолтод заасан сэлбэг хэрэгслийг нийлүүлэх үргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт тухайн этгээд өөрөө гүйцэтгэх, эсхүл уг тендерт оролцогчийн Монгол Улсад байгуулсан, эсхүл байгуулагдах төлөөлөгч биелүүлэх тухай баримт;

(е) захиалагч тендерт оролцогчийн харилцагч банкнаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн мэдэгдэл;

(ё)одоогийн ба сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл;

(ж)гэрээний үнийн 10-аас дээш хувьтай тэнцэх дүнтэй ажлыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх бол түүний чадварын талаарх мэдээлэл.

18.2. Тендерт оролцогч ТОӨЗ-ны 1.1-д заасан барааг нийлүүлэх гэрээг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:

(а) сүүлийн 5 жилийн аль нэг жилд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ нь ТШӨХ-д заасан дүнгээс багагүй байх;

(б)сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй, доод тал нь нэг бараа нийлүүлэх үндсэн гүйцэтгэгчээр ажилласан туршлага;

(в)ТШӨХ-д заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг цаг хугацаанд нь (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах санал;

(г) бусад гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглаж буй хөрөнгө болон энэ гэрээний дагуу хийгдэх болох урьдчилгаа төлбөрийг оролцуулахгүйгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээл нь ТШӨХ-д дурдсан дүнгээс багагүй байх.

(д) Сүүлийн ТШӨХ-д дурдсан жилийн хугацаанд ашигтай ажилласан байх.

18.3. Тендерт оролцогч түншлэл нь 18.2(а) ба (г)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмнэ. Гэхдээ гишүүн тус бүр 18.2 (а), (б), (г) -д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байна.

Энэ шаардлагыг биөлүүлээгүй тохиолдолд түншлэлийг тухайн чадварын шаардлагуудыг хангаагүй гэж үзэж тендерээс нь татгалзана. ТШӨХ-д өөрөөр заагаагүй тохиолдолд тендерт оролцогч чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлоход түүний туслан гүйцэтгэгчийн ажлын туршлага, нөөц бололцоог харгалзан үзэхгүй.

Тендерт оролцогч 18.2(б) ба (в)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохдоо түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмж тооцно.

18.4. ТШӨХ-д тусгайлан заасан бол Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд 10 хувийн давуу эрх олгоно. Монгол Улсын гарал өндөрлөлтэй бараа нийлүүлэх тендерт оролцогч давуу эрх эдлэх хүсэлтэй бол энэ тухайгаа нотлоход шаардлагатай баримт, материалыг тендертэй хамт ирүүлэх хэрэгтэй.

#### **19. Нийлүүлэх бараа нь тендерийн баримт бичгийн шаардлагад нийцэж буйг нотлох баримт**

19.1. Тендерт оролцогч, түүний нийлүүлэх бараа нь захиалгчийн шаардсан техникийн тодорхойлолт болон стандартад нийцэж буйг нотлох баримтыг тусгайлан бэлтгэж тендерт ирүүлнэ. Нотлох баримт нь нийтлэл, зураг, өгөгдлийн хэлбэрээр байж болох ба дараах мэдээллийг агуулна.

Үүнд: (а) барааны техникийн болон үйл ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт;

(б) барааг [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалт. Тус жагсаалтад тэдгээрийг аль улсаас, хаанаас нийлүүлэх боломжтойг, мөн нэгж үнэ зэрэг холбогдох мэдээллийг дурдана;

(в) нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалгчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдэл;

(г) захиалгчийн техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал болон тоног төхөөрөмжийн стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд түүгээр хязгаарлагдахгүйг тендерт оролцогч анхаарч 19.1.(в)-ийн дагуу тайлбар ирүүлнэ. Тендерт өөр стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаарыг орлуулан хэрэглэж болох бөгөөд орлуулах зүйл нь техникийн тодорхойлолтод заасантай дүйцэхүйц, эсхүл түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг тендерт оролцогч захиалагчид нотлон харуулна.

#### **20. Тендер хүчинтэй байх хугацаа**

20.1. Тендерийн хүчинтэй байх хугацаа нь хуульд заасан хүчинтэй байх хугацаанаас богино байх тохиолдолд захиалагч түүнийг үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж татгалзана.

#### **21. Тендерийн баталгаа**

21.1. ТШӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч нь ТШӨХ-д заасан үнийн дүнтэй тэнцэх тендерийн баталгааг ирүүлнэ.

21.2. Тендер шалгаруулалт олон багцтай бол нэг тендерийн баталгаа гаргаж, түүнд багц тус бүрээр тодорхойлж ирүүлнэ.

21.3. Захиалагч тендерийн баталгааны хэмжээг багц тус бүрийн төсөвт өртгийн 1-2 хувиар тооцож ТШӨХ-д заана.

21.4. Тендерийн баталгаа нь Монгол Улсын, эсхүл гадаадын нэр хүндтэй банкны гаргасан баталгаа, Засгийн газрын бонд эсхүл Засгийн газраас хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр байж болно.

Тендерийн баталгааг 4 дүгээр бүлэг дэх маягтаар, эсхүл тендер хүлээн авахаас өмнө захиалагч урьдчилан хүлээн зөвшөөрсөн маягтаар ирүүлнэ. Тендерийн баталгаа нь тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

21.5. Тендерийн баталгааны эх хувийг ирүүлэхдээ захиалагчийн ТШӨХ-д заасан хоног (он, сар, өдөр)-оор тооцож ирүүлнэ.

21.6. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

21.7. Энэ зүйлд шаардсаны дагуу хүлээн зөвшөөрөхүйц тендерийн баталгаа ирүүлээгүй аливаа тендерээс захиалагч үндсэн шаардлага хангагүй гэж үзэж татгалзана.

21.8. Тендер нь шалгаргаагүй оролцогчийн тендерийн баталгааг 20.1-д заасан тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногт багтаан хүчингүй болгоно.

21.9. Тендер нь шалгарсан оролцогчийн тендерийн баталгааг ТОӨЗ-ны 41 дүгээр зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зурж, ТОӨЗ-ны 42 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлсэн тохиолдолд хүчингүй болгоно.

## **21.10. Тендерийн баталгааг дараах тохиолдолд улсын орлого болгоно.**

Үүнд: (а) тендер нээсний дараа тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан, эсхүл буцааж авахыг бичгээр мэдэгдсэн;

(б) тендерт оролцогч 32.2-ын дагуу тендерийн үнэд хийсэн залруултыг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд ТОӨЗ-ын 38.2-т заасан нөхцөл үүссэн бол;

(в) шалгарсан тендерт оролцогч заасан хугацаанд багтаан:

(1)ТОӨЗ-ны 41 дүгээр зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зураагүй;

(2)ТОӨЗ-ны 42 дугаар зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй.

## **22. Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах**

22.1. Тендерт оролцогч 12 дугаар зүйлд заасан тендерийн бүрдэл баримт бичгийн эх хувиудыг бэлтгэн хавтаслаж, түүнд “ЭХ ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ.

Тендерт оролцогч үүнээс гадна ТШӨХ-д заасан тоо ширхэг бүхий тендерийн хуулбар хувийг бэлтгэн хавтаслаж “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ.

Эх хувь болон хуулбар хувиуд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд эх хувийг баримтална.

22.2. Тендерийн эх болон хуулбар хувиудыг хэвлэж (компьютер, бичгийн машин гэх мэт), эсхүл арилдаггүй бэхээр бичиж, тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулна.

Тендерт оролцогчийн боловсруулсан тендерийн агуулга, үнэтэй холбоотой бүх хуудсанд төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурна. Хэвлэмэл танилцуулга, тайлан болон бусад байгууллагын гаргасан албан ёсны мэдээлэл зэрэг баримт бичиг үүнд хамаарахгүй.

22.3. Тендер ирүүлэхээс өмнө захиалагчийн гаргасан зааварчилгаатай нийцүүлэх, эсхүл тендерт оролцогч өөрийн алдааг зайлшгүй шаардлагаар засахаас бусад тохиолдолд тендерт ямар нэг засвар, нэмэлт бичилт хийхгүй ба засвар, нэмэлт бичилт хийсэн тохиолдолд зөвхөн дээрх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар тэдгээр засвар өөрчлөлтийг хүчинтэйд тооцно.

## **Г. ТЕНДЕР ИРҮҮЛЭХ**

### **23. Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх**

23.1. Тендерт оролцогч өөрийн тендерийг шуудангаар, эсхүл өөрийн бие төлөөлөгчөөр захиалагчид хүргүүлнэ.

23.2. Тендерийн эх болон хуулбар хувиудыг тус тусад нь “ЭХ ХУВЬ”, “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн бичиглэл бүхий дугтуйнд хийж битүүмжлэн тэдгээрийг дахин давхар нэг дугтуйнд (гаднах) хийж битүүмжилнэ. Тендерээ дугтуйлж, битүүмжлэхдээ ТОӨЗ-ны 23.3, 23.4-т заасныг баримтална.

23.3. Доторх ба гаднах дугтуйнууд дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд: (а) тендерт оролцогчийн нэр, хаягтай байх;

(б) ТШӨХ-д заасан хаягаар ТОӨЗ-ны 1.1-т заасан захиалагчийн нэр дээр хаяглах; (в) тендер шалгаруулалтыг таних, ялгах тэмдэг болгож ТОӨЗ-ны 1.1 болон ТШӨХ-д тодорхойлсон тендер шалгаруулалтын нэр/дугаарыг тодорхой бичсэн байх;

(г) ТОӨЗ-ны 28.1-т заасан хугацаанаас өмнө “НЭЭЖ ҮЛ БОЛНО” гэж тэмдэглэгдсэн байх.

23.4. Хэрэв бүх дугтуйг 23.3-т заасан шаардлагын дагуу битүүмжилж, бичиглэл хийгээгүй нөхцөлд уг тендер буруу хаягаар хүргэгдсэн, эсхүл тендер нээхээс өмнө битүүмжлэл задарсан тохиолдолд захиалагч хариуцлага хүлээхгүй.

23.5. ТОӨЗ-ны 23.1-т зааснаас өөр хэлбэрээр ирүүлсэн аливаа тендерийг захиалагч хүлээж авахгүй бөгөөд түүнийг хаягаар нь буцааана.

#### **24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

24.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

24.2. Захиалагч ТОӨЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсны улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд захиалагч болон тендерт оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр хадгалагдана.

#### **25. Хугацаа хоцорсон тендер**

25.1. Захиалагч ТОӨЗ-ны 24 дүгээр зүйлд заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирлсүэн аливаа тендерийг “хугацаа хоцорсон” гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр буцаана.

#### **26. Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх**

26.1. Аливаа этгээд дангаараа, эсхүл хамтран ажиллах гэрээний үндсэн дээр түншлэл болж тендер шалгаруулалтад оролцохдоо зөвхөн нэг тендер ирүүлнэ.

Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүд нэгээс дээш тендер ирүүлсэн, бол түүний ирүүлсэн бүх тендерээс татгалзана.

#### **27. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах**

27.1. Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагчид бичгээр мэдэгдэл өгсний үндсэн дээр өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, солих, эсхүл түүнийг буцааж авах эрхтэй.

27.2. Тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, тендерийг солих эсвэл буцааж авах мэдэгдлийг 22, 23 дугаар зүйлийн дагуу бэлтгэн, битүүмжилж, бичиглэл хийхийн хамт доторх ба гаднах дугтуй дээр “НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”, “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ”, эсхүл “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн бичиглэл хийнэ.

Тендерийг буцааж авах мэдэгдлийг утсан холбоогоор ирүүлж болох ба энэ мэдэгдэл хүчин төгөлдөр болохыг батламжилж гарын үсэг, тамга бүхий эх хувийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө заавал ирүүлнэ.

27.3. Тендер хүлээн авах эцсийн хугацаа өнгөрснөөс хойш аливаа тендерт ямар нэг нэмэлт өөрчлөлт хийх, солих, эсвэл буцааж авахыг зөвшөөрөхгүй.

27.4. ТОӨЗ-ны 27.2-т заасны дагуу тендерээ буцааж авах тухай хүсэлт ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүйгээр буцаан олгоно.

27.5. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас тендер хүчинтэй байх хугацааны хооронд тендерийг буцааж авах нь 21 дүгээр зүйлийн дагуу тендерийн баталгааг улсын орлого болгох үндэслэл болно.

## **Д. ТЕНДЕРИЙГ НЭЭХ, ҮНЭЛЭХ**

### **28. Тендерийг нээх**

28.1. Захиалагч тендерийн нээлтийг ТШӨХ-д заасан огноо, цагт, заасан хаяг бүхий газарт зохион байгуулна. Тендер нээх үед тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцах эрхтэй ба байлцсан бол тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсгээ зурна.

28.2. Захиалагч эхлээд “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн бичиглэл бүхий дугтуйг нээж, зарлах бөгөөд энэ хүсэлтийг ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүйгээр буцаана.

Дараа нь “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ” бичиглэл бүхий тендерийг нээж зарлах бөгөөд уг тендерийг ирүүлсэн оролцогчийн урьд ирүүлсэн тендерийг нээлгүйгээр түүнд буцаан олгоно.

“ТЕНДЕРТ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” бичиглэл бүхий дугтуйг түүнд харгалзах үндсэн тендерийн хамт нээж нийтэд зарлана.

28.3. Тендерийг нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, санал болгосон бол үнийн хөнгөлөлт, хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд түүний үнэ, тендерийн баталгаа байгаа эсэх, оролцогч өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан бол уг нэмэлт өөрчлөлтийг болон захиалагч шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэнэ.

Тендер нээх үед зарлагаагүй тендерийн үнэ, үнийн хөнгөлөлт болон хувилбарт тендерийг үнэлгээнд харгалзахгүй.

28.4. Захиалагч тендерийн нээлтийн тэмдэглэлийг хөтлөх бөгөөө уг тэмдэглэл нь дараах мэдээллийг заавал агуулсан байна. Үүнд:

(а) тендерт оролцогчийн нэр болон тухайн тендерт оролцогч тендерээ буцааж авсан, эсхүл тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан буюу тендерээ сольсон эсэх;

(б)тендерийн үнэ болон санал болгосон үнийн хөнгөлөлт (зөвшөөрсөн бол хувилбарт тендерийн үнэ). Нэгээс дээш багцтай тендер шалгаруулалтын үед эдгээр мэдээллийг багц тус бүрээр гаргах;

(в) захиалагч тендерийн баталгаа шаардсан бол түүнийг ирүүлсэн эсэх.

### **29. Нууцлах**

29.1. Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд тендерт оролцогчид болон тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй аливаа этгээдэд задруулахыг хориглоно.

29.2. Захиалагч тендерийг хянан үзэх, үнэлэх, харьцуулах явцад, эсхүл гэрээ байгуулах эрх олгох шийдвэрт тендерт оролцогчоос нөлөөлөх гэсэн аливаа оролдлого нь тухайн оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болно.

29.3. Тендерийн нээлт хийснээс хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд захиалагч болон тендерт оролцогчид хоорондоо зөвхөн бичгээр харилцана.

### **30. Тендерийг тодруулах**

30.1. Тендерийг хянан үзэх, үнэлэх болон харьцуулах явцад тендерийг үнэлэхэд зайлшгүй шаардлагатай бол захиалагч тендерт оролцогчоос түүний тендерийн талаар тодруулга ирүүлэхийг хүсч болно.

Тендерийг тодруулахтай холбоотой аливаа харилцааг бичгээр явуулна. Гэхдээ 31 дүгээр зүйлийн дагуу тендерийг хянан үзсэний үндсэн дээр захиалагчийн илрүүлсэн арифметик алдааг залруулахаас бусад тохиолдолд тендерийн үнэ болон агуулгад ямар нэг өөрчлөлт хийхийг хүсэх, санал болгохыг зөвшөөрөхгүй.

### **31. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох**

31.1. Аливаа тендерийг нарийвчлан үнэлэхээс өмнө уг тендер нь дараах шаардлагыг хангаж буй эсэхийг хянан үзнэ. Үүнд:

- (а)ТОӨЗ-ны 4 дүгээр зүйлд заасан эрх бүхий тендерт оролцогч байх шаардлагыг хангасан эсэх;
- (б)тендерт зохих ёсоор гарын үсэг зурж, баталгаажуулсан эсэх;
- (в) зөвшөөрөгдсөн маягтын дагуу захиалагчийн шаардлагыг хангасан тендериин баталгаа ирүүлсэн эсэх;
- (г) тендериин баримт бичигт тавигдсан бусад шаардлагад нийцсэн эсэх;
- (д)тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадварын доод шаардлагыг хангасан эсэх.

31.2.ТОӨЗ-ны 31.1 дэх заалтын (а)-(д)-д заасан заалт тус бүрийг хангаж буй тохиолдолд шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.

31.3. Шаардлагад нийцсэн тендер гэж тендериин баримт бичгийн бүх нөхцөл болзول, тендерт оролцогчийн үйлдвэрлэлийн хүчин чадал, санал болгосон бараа нь ТОӨЗ-ны 19 дүгээр зүйлд заасан нөхцөл болон техникийн тодорхойлолтыг материаллаг зөрүүгүйгээр хангаж буй тендериийг хэлнэ.

Дор дурдсан зүйлсийг материаллаг зөрүү гэж үзнэ. Үүнд:

(а) тендерт санал болгож буй бараа нь техникийн тодорхойлолт болон гэрээний нөхцөлд тодорхойлсон барааны хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээр бол;

(б)гэрээнд заасан захиалагчийн эрх, тендерт оролцогчийн үүрэгт тендериин баримт бичигтэй үл нийцэх зарчмын хязгаарлалт оруулсан бол;

(в) Зөрүүг хүлээн зөвшөөрч засварлах буюу запруулах нь шаардлагад нийцсэн бусад тендериин өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөх бол.

31.4. Захиалагч шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон тендерээс татгалзана. Харин тендерт оролцогч түүнд засвар хийж шаардлагад нийцсэн болгож болохгүй.

### **32. Алдааг залруулах**

32.1. Захиалагч шаардлагад нийцсэн гэж тодорхойлогдсон тендериин арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна. Үүнд:

(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнд зөв гэж үзэж тоонд дүнг засварлах;

(б)нэр төрлийн нийт үнийн нийлбэр нь тендериин маягтад заасан тендериин нийт үнээс зөрвөл нэр төрлийн нийт үнийн нийлбэрийг үндэслэн тендериин нийт үнийг залруулах;

(в) нэр төрлийн нийт үнэ нь түүний нэгж үнийг тоо ширхэгээр үржүүлэхэд гарсан үнээс зөрвөл нэр төрлийн нэгж үнийг үндэслэн түүний нийт үнийг залруулна. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхийлэгдсэнд зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

32.2. Захиалагч, “хамгийн сайн” үнэлэгдсэн тендериин үнэнд залруулга хийхээр байвал энэ талаар тухайн тендерт оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрсөн эсэхийг бичгээр баталгаажуулж авна.

### **33. Нэг валютад хөрвүүлэх**

33.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол банкнаас албан ёсоор зөвшөөрсөн тохиолдол ТОӨЗ-ны 16 дугаар зүйлд зааснаас өөр валютаар тендериин үнийг илэрхийлж болно. Ийм тохиолдолд захиалагч тендериин үнэлгээ, харьцуулалтыг хийхдээ тендериин үнийг тендер зарласан өдрийн Монгол банкны ханшаар төгрөгт хөрвүүлнэ.

### **34. Дотоодын давуу эрх**

34.1. Захиалагч ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерүүдийг үнэлж харьцуулахдаа Монгол Улсын гарал үүсэлтэй бараа санал болгосон тендерт бусад гарал үүсэлтэй бараа санал болгосон тендертэй харьцуулахад давуу эрхийн зөрүү олгохгүй.

### **35. Тендерийг үнэлэх, харьцуулах**

35.1. Захиалагч зөвхөн 31 дүгээр зүйлийн дагуу шаардлагад нийцсэн гэж тогтоогдсон тендерийг үнэлж, харьцуулна.

35.2. Захиалагч тендерийг үнэлэхдээ дараах байдлаар тендерийн үнэд залруулга хийж, тендерийн харьцуулах үнийг тодорхойлно. Үүнд: (а)ТОӨЗ-ны 32 дугаар зүйлийн дагуу арифметик алдааг тооцож тендерийн үнийг залруулах;

(б)ТОӨЗ-ны 31.3дугаар зүйлийн дагуу томоохон зөрүү гэж тооцоогүй бага хэмжээний орхигдуулсан зүйл буюу тоо хэмжээний зөрүүг тооцон мөнгөөр р илэрхийлж, тендерийн үнэд залруулга хийх;

(в) тендерт оролцогчийн санал болгосон нэмэлт өөрчлөлт буюу үнийн хөнгөлөлтийг тусгах;

(г) захиалагч энэ тендерийн баримт бичгийн 3 дугаар бүлэг буюу үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг түүнд холбогдох аргачлалын дагуу тооцон мөнгөөр илэрхийлж, түүнийг тендерийн үнэд нэмж тооцох;

(д) ТШӨХ-д зөвшөөрсөн бол дотоодын давуу эрхийн зөрүүг холбогдох аргачлалын дагуу тооцох.

35.3. Шаардлагад нийцсэн тендерүүдийг 35.2-т заасны дагуу үнэлгээ хийж тендер тус бүрийн харьцуулах үнийг тогтооно. Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж шалгаруулна.

35.4. ТШӨХ-д заасны дагуу хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд “хамгийн сайн” үнэлэгдсэн үндсэн тендерийн хувилбарт тендер үндсэн тендерээс илүү нөхцөл хангасан бол хувилбарт тендерийг шалгаруулна.

5.5. Барааг ТОӨЗ-ны 1.2 дахь хэсэгт хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол захиалагч үнэлгээг багц тус бүрт хийх бөгөөд харин гэрээ байгуулах эрх олгоходо нэг багц, хэд хэдэн багц, эсхүл бүх багцын аль үр ашигтай хувилбарыг сонгож болно.

35.6. Олон багцтай тендер шалгаруулалтад “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг шалгаруулж, тэдгээрт гэрээ байгуулах эрх олгох хамгийн үр ашигтай хувилбарыг сонгоходо захиалагч 3 дугаар бүлэг буюу үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт дэхь олон багцтай тендерийг үнэлэх тухай тусгайлан заасан аргачлалыг мөрдөнө.

### **36. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах**

36.1. Захиалагч шаардлагад нийцсэн, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг дахин магадлаж болно.

36.2. Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлохдоо ТОӨЗ-ны 18.1-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТОӨЗ-ны 30 дугаар зүйлийн дагуу хийсэн шаардлагатай нэмэлт тодруулгад үндэслэн ТОӨЗ-ны 18.2-т заасан чадварын шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлно.

Захиалагч 18.2 болон тендерийн үнэлгээнд харгалзах чадварын шалгуур үзүүлэлтэд заагаагүй бусад шалгуур үзүүлэлтийг тендерийг хянан үзэх, тендерт оролцогчийн чадварыг тогтооход ашиглахгүй.

36.3. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаад, шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгоно. Хэрэв шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалzan сайн гэж үнэлэгдсэн дараагийн тендерт оролцогчийн чадварыг мөн адил зарчмаар магадлана.

### **37. Аливаа тендерийг сонгох, эсхүл тендерүүдээс татгалзах захиалагчийн эрх**

37.1. Захиалагч тендер шалгаруулалтыг үндэслэлгүйгээр хүчингүй болгохыг хориглоно.

### **Е. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ**

#### **38. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур**

38.1. Захиалагч шаардлагад нийцсэн бөгөөд 35.3-т заасны дагуу “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.

38.2. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч ТОӨЗ-ны 32 дугаар зүйлийн дагуу захиалагчийн залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөөгүй бол гэрээ байгуулахаас татгалзсан гэж тооцож, тендерээс татгалзах бөгөөд 21.9(б)-д заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгоно.

### **39. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл**

39.1. Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгох шийдвэрээ гаргаж тендер нь шалгарсан оролцогч болон бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр хүргүүлнэ.

39.2. Шалгарсан тухай мэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

39.3. Захиалагч Засгийн газрын худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хуудсанд тендерийн нэр болон багцын дугаарыг дараах мэдээллийн хамтаар гэрээ байгуулах эрх олгосон даруй нийтэлнэ. Үүнд:

- 1) тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;
- 2) тендерийн нээлтэнд зарлагдсан үнийн саналууд;
- 3) нарийвчлан үнэлэгдсэн тендерийн нэр, үнийн санал;
- 4) тендерээс нь татгалзсан оролцогчийн нэр, татгалзсан шалтгаан;
- 5) тендер нь шалгарсан оролцогчийн нэр, түүний санал болгосон тендерийн үнэ, гэрээний үнийн дүн.

39.4. Гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг мэдээлсний дараа шалгараагүй тендерт оролцогч өөрийн тендерийн үнэлгээний талаар тайлбар авах хүсэлтийг бичгээр гаргаж болно. Хүсэлт гаргасан тохиолдолд захиалагч бичгээр хариу өгнө.

39.5. Тендер нь шалгарсан оролцогч ТОӨЗ-ны 42 дугаар зүйлийн дагуу гаргасан гүйцэтгэлийн баталгаа гаргаж, гэрээний маягтанд гарын үсэг зурж ирүүлсэн даруй захиалагч ТОӨЗ-ны 21.8-д заасны дагуу тендерийн баталгааг хүчингүй болгож, энэ тухайг шалгараагүй бусад тендерт оролцогчид мэдэгдэнэ.

### **40. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед тоо хэмжээг өөрчлөх**

40.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх төсөл арга хэмжээний үед захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед үнэ, бусад нөхцөл болзлыг үл өөрчлөн техникийн тодорхойлолтод дурдсан барааны тоо ширхэгийг ТШӨХ-д заасан хувиар өөрчлөх эрхтэй.

### **41. Гэрээнд гарын үсэг зурах**

41.1. Захиалагч гэрээний маягт болон талуудын хооронд тохирсон бүх нөхцөлийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.

41.2. Шалгарсан тендерт оролцогч гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 5-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хугацаанд багтаан түүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.

41.3. Захиалагч шалгарсан тендерт оролцогчийг гүйцэтгэлийн баталгаа ирүүлсний дараа ТОӨЗ-ны 39.4-т нийцүүлэн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.

### **42. Гүйцэтгэлийн баталгаа**

42.1. Гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд заасан хугацаанд багтаан, ТШӨХ, гэрээний тусгай нөхцөлд тусгайлан заасан хэлбэр, дүнгээр ирүүлнэ.

42.2. Шалгарсан тендерт оролцогч ТШӨХ-д тусгайлан заагаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхгүй байж болно.

42.3. Шалгарсан тендерт оролцогч ТОӨЗ-ны 42.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох болон тендерийн баталгааг гүйцэтгүүлэх үндэслэл болно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгэх зааварчилгаа /ТОӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТОӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвэл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТОӨЗ-ны холбогдох заалт	A. Ерөнхий зүйл
ТОӨЗ 1.1	Захиалагч нь: Увс аймгийн Давст сумын Ерөнхий боловсролын сургууль
ТОӨЗ 1.1	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: Сургуулийн дотуур байрны хүүхдийн хоол <b>УВАДСЕБС20240201004</b>
ТОӨЗ 1.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ.</p> <p><b>Дотуур байрны хүүхдийн хоолонд:</b></p> <p>Нэгдүгээр багц: Мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх  Хоёрдугаар багц : Төмс, хүнсний ногоо  Гуравдугаар багц: Бусад, хуурай хүнсний бүтээгдэхүүн  Дөрөвдүгээр багц: Жимс, жимсгэний бүтээгдэхүүн  Тавдугаар багц: Гурил, гурилан бүтээгдэхүүн  Зургаадугаар багц: Сүү, сүүн бүтээгдэхүүн</p> <p><b>Хамрагдах сургуулийн дотуур байрны хүүхдийн тоо:</b>  <b>Давст сумын сургуулийн дотуур байр -49</b></p>
ТОӨЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Улсын төсөв-20.554.820 төгрөг</b>
	<b>Б. Тендерийн баримт бичиг</b>
ТОӨЗ 8.	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: Увс аймгийн Давст сумын ерөнхий боловсролын сургууль:ажлын цагаар 88849597, 99454138
ТОӨЗ 8	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5 хоногоос багагүй байна.
	<b>В. Тендер бэлтгэх</b>
ТОӨЗ 12.1(ё)	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>Сүүлийн 1 жилд /2023 он/ гэрээгээр гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлэлтийн ажлын гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт, нотлох баримтууд /нотариатаар баталгаажуулж ирүүлэх/</li> <li>Гэрээний үүргээ биелүүлсэн талаар өмнөх захиалагчийн үнэлгээ, тодорхойлолтыг заавал ирүүлэх.</li> <li>Голлох мэргэжилтэн, ажилтны танилцуулга, мэргэжлийн үнэмлэх, дипломны хуулбар</li> <li>Барааны техникийн тодорхойлолт, үзүүлэлтийг гаргаж эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж ирүүлэх,</li> <li>Барааны чанарын баталгааны гэрчилгээний хуулбар</li> <li>Тендерийн баримт бичгийн 6, 7-р бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрсөн тухай албан бичгээр мэдэгдэл гаргаж ирүүлнэ.</li> <li>Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай лавлагаа, тодорхойлолтыг тендерт авч ирүүлэх, /эх хувиар/</li> <li>Харьяа татвар, Нийгмийн даатгалын хэлтэс-ийн тодорхойлолт ирүүлнэ /тодорхойлолтууд 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх, хуулбар хувь ирүүлэх бол хуулбарыг нотариатаар батлуулж ирүүлж болно/.</li> <li>Нийлүүлэх барааны баталгаат хугацааны мэдэгдэл гаргаж ирүүлэх.</li> <li>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д</li> </ol>

	<p>заасан нөхцөл байхгүйг бичгээр ирүүлэх. /Тендерт оролцогч нь үнэлгээний хорооны гишүүдэд нөлөөлөх, нөлөөлөхийг оролдсон нь баримтаар нотлогдвол тендерээс татгалзана./</p> <p>11. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</p> <p>12.Ажлын байрны дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар гаргаж ирүүлэх.</p> <p>13. Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шинжилгээний дүгнэлтийн хуулбар</p> <p>14.Хүнсний бүтээгдэхүүн агуулах байрны /зоорь/ гэрчилгээний хуулбар, түрээсийнх бол 2022, 2023, 2024 оны түрээсийн гэрээний хуулбар, зураг ирүүлэх,</p> <p>15.Тендерт оролцогч үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх тухай, үнийн өсөлтөөс хамаарах эрсдлийг өөрөө хариуцах тухай албан бичгээр мэдэгдэл ирүүлэх,</p> <p>16.Улсын болон аймгийн мал эмнэлэгийн лабраторт махаа шилжлуулсэн тухай шинжилгээний дүгнэлт 2024 онд</p> <p>17.Стандарт хэмжил зүйн хэлтсийн баталгаажуулалтанд хамрагдаж тохирлын гэрчилгээ авсан байх / хугацаа дуусаагүй</p> <p>18. Тендерт оролцогчийн багаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт</p> <p>19.Хүнсний үйлдвэрлэл явуулах зөвшөөрөл,</p> <p>20 Бүтээгдэхүүний жагсаалт</p> <p>21. Тухайн бүтээгдэхүүний өртөг үнийн санал</p> <p>22. Ажилчдын эрүүл мэндийн байдлыг тодорхойлсон мэргэжлийн байгууллагын үзлэг, шинжилгээний бичиг ирүүлэх.</p>
	<p>30. Дээрх материалуудыг <b>ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно</b></p>
<b>ТОӨЗ 14.1</b>	Хувилбарт тендер ирүүлэхийг <b>“зөвшөөрөхгүй”</b> .
<b>ТОӨЗ 15.5</b>	Олон улсын худалдааны Incoterms/Инкотермс-ийн хувилбар:хэвлэгдсэн оныг нь оруул.: “Incoterms 2009”
<b>ТОӨЗ 15.9 б) (1) and (в) (3)</b>	Бараа хүргэгдэх газар:Увс аймгийн Давст сумын ЕБСургууль,
<b>(ТОӨЗ 15.9 (а) (3);(б)(3) болон (в)(5)</b>	“Бараа хүргэгдэх эцсийн цэг: (Захиалагчийн агуулах, эсхүл барааг эцсийн хэрэглэгчид хүргэх байршил)”: Гэрээнд заасан хуваарийн дагуу шалгарсан оролцогчид багц тус бүрийн барааг захиалагчийн заасан газарт нийлүүлэх үүрэг хүлээнэ.
<b>ТОӨЗ 15.9 (б) (1)</b>	Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь ТОӨЗ-ны 15.9.(б).(1) дэх хэсэгт заасан <b>захиалагчийн нутаг дэвсгэр дэхь нэрлэсэн байрлал хүртэлх СИП / СИР үнэ байна</b> .
ТОӨЗ 15.10	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад <b>“тогтол байна”</b>
ТОӨЗ 16.1	Тендерийн валют: <b>Төгрөг байна</b> .
ТОӨЗ 18.1 (а)	Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: <b>“шаардлагатай”</b> Тендерт оролцогч тухайн барааны үйлдвэрлэгч, нийлүүлэлгчийн зөвшөөрлийн хуулбарыг ирүүлнэ. Санал болгож буй барааны гарал үүслийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ.
ТОӨЗ 18.1 (б)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2023 оны жил эцсийн тайлан
ТОӨЗ 18.1 (г)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 1 жил тухайн бараатай ижил төстэй нийлүүлэлт хийж байсан талаар мэдээлэл ирүүлэх/ ижил төстэй бараа нийлүүлж байсан талаарх гэрээний хуулбарыг ирүүлэх /МАЯГТ№ТШМ-5Бдагуу ирүүлнэ./
ТОӨЗ 18.1 (д)	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ:
ТОӨЗ 18.2 (а)	Борлуулалтын хэмжээ: Шаардахгүй
ТОӨЗ 18.2 (б)	Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: 1 жил

ТОӨЗ 18.2 (в)	Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: <b>Шаардлагатай</b> : Үүнд: 1.Жин хэмжүүр-1, баталгаажсан байна. 2.хөргөч, хөлдөөгч-зориулалтын 3.зоорь, агуулах-стандартын шаардлага хангасан байна. Эдгээрийн гэрчилгээний хуулбар, зураг зэргийг ирүүлж нотлоно. Агуулах байрны гэрчилгээний хуулбар, түрээсийнх бол 2023 оны түрээсийн гэрээг ирүүлэх.
ТОӨЗ 18.2 (г)	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: <u>Шаардахгүй</u>
ТОӨЗ 18.2 (д)	Ашигтай ажилласан байх жилийн тоо: 2023 онд ашигтай ажилласан байна.
ТОӨЗ 18.4	Дотоодын давуу эрхийн зөрүү: “тооцохгүй”
ТОӨЗ 19.1.(б)	Барааг тасралтгүй горимын дагуу ашиглах, эсхүл ажиллуулахаар тооцоолж буй хугацааны үе (энэ хугацаанд шаардагдах сэлбэг хэрэгслийг тооцоолох зорилготой): 1жил
ТОӨЗ 20.1	Тендер нээнээс хойш 45 хоногийн туршид хүчинтэй байна
. ТОӨЗ 21.1	Тендерийн баталгааны үнийн дүн:0
ТОӨЗ 22.1	Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: 0 хувь
	<b>Г. Тендер ирүүлэх</b>
ТОӨЗ 23.3 (а)	Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: Тендер хүлээн авах этгээд: Тендерийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 09.00 цагаас өмнө <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар ирүүлэх Байгууллагын хаяг: Увс аймгийн Давст сумын сургууль Аймаг, хот: Увс аймаг Давст сум Шуудангийн дугаар: Угүй Улс: “Монгол Улс”
ТОӨЗ 23.3 (б)	Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ: Сургуулийн дотуур байрны хүүхдийн хоол <b>УВАДСЕБС20240201001</b>
ТОӨЗ 24.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа: Огноо: 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 10 цаг 00 минутад
	<b>Д. Тендерийг нээх, үнэлэх</b>
ТОӨЗ 28.1	<b>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв.</b> Үүнд: Байшин, гудамжны нэр: <b>Увс аймаг Давст сумын өрөнхий боловсролын сургууль</b> Өрөөний дугаар:Увс аймаг Давст сум ЕБС-ийн Хүүхэд хөгжлийн өрөөнд Аймаг, хот: Увс аймаг. Давст сум Шуудангийн дугаар:Угүй Улс:“Монгол Улс” Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут <b>E. Гэрээ байгуулах эрх олгох</b>
ТОӨЗ 40.1	Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: <b>Угүй</b> Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: <b>Угүй</b>
ТОӨЗ 42.1	Гүйцэтгэлийн баталгаа:

**ХОЁРДУГААР ХЭСЭГ**  
**ТАВДУГААР БҮЛЭГ**  
**БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТЕХНИКИЙН**  
**ТОДОРХОЙЛОЛТ**

**АГУУЛГА:**

- 1. БАРААНЫ НЭР ТӨРЛИЙН ЖАГСААЛТ БОЛОН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**
- 2. ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВААРЬ**
- 3. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**
- 4. ШАЛГАЛТ БОЛОН ТУРШИЛТ**

**1. Дотуур байрны хүүхдийн хоолонд:**

Нэгдүгээр багц: Max, махан бүтээгдэхүүн нийлүүлэх

Хоёрдугаар багц : Төмс, хүнсний ногоо

Гуравдугаар багц: Бусад, хуурай хүнсний бүтээгдэхүүн

Дөрөвдүгээр багц: Жимс, жимсгэний бүтээгдэхүүн

Тавдугаар багц: Гурил, гурилан бүтээгдэхүүн

Зургаадугаар багц: Сүү, сүүн бүтээгдэхүүн

**Хамрагдах сургуулийн хүүхдийн тоо:** Давст сумын ЕБСургууль дотуур байр – 49 хүүхэд

Санал болгож буй ундааны зүйлсийн нэг хүнд ноогдох үнийн санал, хэмжээ, орц зэргийг тодорхой үнийн саналд хавсаргана. Ундааны зүйл болон гурил гурилан бүтээгдэхүүн нь нэг өдөрт олгох илчлэгийн хэмжээг хангаж байх бөгөөд 7 хоногийн дундаж дүнгээр 4000 төгрөгт багтсан байна.

Нэг хүнд олгох бүтээгдэхүүний илчлэгийн хэмжээ, мөнгөн дүнг өөрчлөхгүйгээр санал болгож буй бүтээгдэхүүнийг сэлгэх замаар цэсийг өөрчлөн олгож болно.

Тендерт ялсан тохиолдолд 2024 оны 05 сарын 24-өөс дотуур байрны хүүхдийн хоолоор үйлчилж эхлэх бөгөөд бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулсан байх шаардлагатай.

**Техникийн тодорхойлолт тавигдах шаардлага**

**Барааны тодорхойлолт:** Дотуур байрны хүүхдийн хоолонд нийлүүлэгдэх бүтээгдэхүүн нь дараах багцтай байна.

**1-р багц : Max**

**Тухайн багцад тавигдах шаардлага:** Эрүүл ахуй, ариун цэвэр, хүнсний бүтээгдэхүүний чанар, хадгалалтын шаардлагыг бүрэн хангасан байх . Max бохирдлоос хамгаалж тусгай уут, сав баглаа боодолтой байх ба хуучраагүй, элдэв бусын бохирдолгүй, жинд нөлөөлөхүйц дайвар бүтээгдэхүүн байхгүй байх. \цус, уушги, бөөр зүрх, цагаан мах гэх мэт\

Үнийн саналыг тухайн үеийн зах зээлийн ханшид нийцүүлж улирал бүрээр ирүүлэх /хонь, үхэр/

**2-р багц: Бусад, хуурай хүнсний бүтээгдэхүүн, кг-ийн бүтээгдэхүүн**

Тухайн багцад санал болгож буй бүтээгдэхүүн нь нь хүүхдийн хоолонд оролцох хэрэглээний сагсны төрлөөс сонгох ба тус бүтээгдэхүүний гарал үүслийн бичиг, үйлдвэрлэсэн он сар өдөр, үйлдвэрлэсэн газар тодорхой байна. Мөн чанарын баталгаатай байх ба хадгалах хугацаа, болон одоо хадгалаж байгаа склад нь стандартын дагуу байх шаардлагатай. Гарал үүслийн гэрчилгээтэй байх. Хадгалалтын горим алдагдаагүй байх.

**3-р багц:Жимс, жимсгэнэ**

Тухайн багцад санал болгож буй бүтээгдэхүүн нь горимын дагуу хадгалагдсан, эрүүл ахуйн шаардлага хангасан, бүтээгдэхүүн хадгалах зориулалтын зоорь хөргүүртэй байх.

**1. Тавигдах шаардлага, хяналт:** Бүтээгдэхүүний орц норм болон тендерийн шаардлага, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн явцад захиалагчийн зүгээс хэсэгчилсэн болон бүрэн хяналт шалгалтыг хийж байна. Бүтээгдэхүүн бүрийн үйлдвэрлэсэн хугацаа тодорхой, зориулалтын савлагаатай байна.

#### **4-р багц: Гурил, гурилан бүтээгдэхүүн**

Тухайн багцад тавигдах шаардлага: Эрүүл ахуй, ариун цэвэр, хүнсний бүтээгдэхүүний чанар, хадгалалтын шаардлагыг бүрэн хангасан, мэргэжлийн хяналтын газрын дүгнэлттэй байх. Элдэв хольц хоггүй, үнэр амтгүй шаардлага хангасан. Ут сав баглаа боодол бүрэн бүтэн. Ус чийг, хөгцүүсээгүй хадгалалтын горим алдагдаагүй эрүүл ахуйн шаардлага хангасан байх.

#### **5-р багц: Сүү, сүүн бүтээгдэхүүн**

Тухайн багцад санал болгож буй бүтээгдэхүүн нь гарал үүслийн бичигтэй байх. Мал эмнэлгийн бичигтэй шинжилгээнд орсон байх. Бүтээгдэхүүн нь нян судлалын шинжилгээнд хамрагдсан байх. Элдэв хольцгүй, гадны үнэр амтгүй, цэвэр малын сүү, сүүгээр хийсэн бүтээгдэхүүн байх. Эрүүл ахуй, ариун цэвэр, хүнсний бүтээгдэхүүний чанар, хадгалалтын шаардлагыг бүрэн хангасан байх.

Үнийн саналыг тухайн үеийн зах зээлийн ханшид нийцүүлж улирал бүрээр ирүүлэх

#### **6-р багц: Хүнсний ногоо**

Тухайн багцад санал болгож буй бүтээгдэхүүн нь эрүүл ахуйн шаардлага хангасан байх. Элдэв шавьж хорхой идээгүй байх. Хөлдөж муудсан, зөвлөрсөн гэх мэт хадгалалтын горим алдагдаагүй байх/нэг жилийн хэрэгцээ

Үнийн саналыг тухайн үеийн зах зээлийн ханшид нийцүүлж улирал бүрээр ирүүлэх

#### **1-р багц : Max**

#### **Тухайн багцад тавигдах шаардлага:**

№	Нэр төрөл	Тодорхойлолт ба гарал үүсэл
1	Үхрийн мах	I зэргийн , гарал үүсэл, шинжилгээний бичигтэй , эрүүл ахуйн шаардлага хангасан ,стандартад нийцсэн байх, илчлэг сайтай, эцэг малын мах хорих, мах бэлтгэл маш цэвэр стандартын шаардлага хангасан байх, өнгө зүс сайтай өөх мах алагласан, мах бохирдлоос хамгаалж тусгай уут, сав баглаа боодолтой байх ба хуучраагүй, элдэв бусын бохирдолгүй, жинд нөлөөлөхүйц дайвар бүтээгдэхүүн байхгүй байх. \цус, уушги, бөөр зүрх, цагаан мах гэх мэт\
2	Хонины мах	

Тендерт оролцогчийн нэр:.....

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга .....

Албан тушаал, нэр: .....

Хаяг: .....

ЖИЧ: Нийлүүлэх бараа нэг бүрийг жагсаан бичээд нэг бүрийн үнийг тодорхой тавьж өгнө. Үнийн саналыг тухайн үеийн зах зээлийн ханшид нийцүүлж улирал бүрээр ирүүлэх

#### **2-р багц: Бусад, хуурай хүнсний бүтээгдэхүүн, кг-ийн бүтээгдэхүүн**

№	Нэр төрөл	Тодорхойлолт ба гарал үүсэл
1	Элсэн чихэр	Шинжилгээний бичигтэй сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, өнгө цагаан , нарийн ширхэгтэй амт сайтай, Солонгос , орос улсад үйлдвэрлэсэн.
2	Хүнсний сода	Стандартад нийцсэн, шошготой, монгол улсад үйлдвэрлэсэн,
3	Масло	Шинжилгээний бичигтэй сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, монгол,орос улсад үйлдвэрлэсэн, кг-аар давласан
4	Вариань	Шинжилгээний бичигтэй сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, орос монгол улсад үйлдвэрлэсэн,илчлэг сайтай
5	Давс	

6	Далайн байцаа	Шинжилгээний бичигтэй сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, монгол, оросулсад үйлдвэрлэсэн, хадгалалтын горим алдагдаагүй байх
7	Шөлний далайн байцаа	
8	Өндөг	
9	Үргамлын тос	Шинжилгээний бичигтэй сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, монгол, орос, солонгос, орос улсад үйлдвэрлэсэн
10	Цагаан будаа	
11	Исгэгч /хөөлт/	
12	Майноз	
13	Сийр /бяслаг/	
14	Шар цай	Шинжилгээний бичигтэй сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, монгол, орос улсад үйлдвэрлэсэн,

Тухайн багцад санал болгож буй бүтээгдэхүүн нь хугацаа хаяг шошго тодорхой байх. Гарал үүслийн гэрчилгээтэй байх. Хадгалалтын горим алдагдаагүй байх.

/Нэг сарын хэрэгцээ цагаан будаа кг, элсэн сахар кг, /

### 3-р багц: Жимс, жимсгэнэ

№	Нэр төрөл	Тодорхойлолт ба гарал үүсэл
1	Аньсны шүүс	Цэвэр байгалийн гаралтай, Шинжилгээний бичигтэй сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой,
2	Зөгийн бал	
3	Үхрийн нүдний шүүс	
4	Чацарганы шүүс	
5	Хатаасан алим	Шинжилгээний бичигтэй сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, орос улсад үйлдвэрлэсэн
6	Алим	
7	Мандарин	
8	Гадил	
9	Өргөст хэмх	
10	Улаан лооль	
11	Хар чавга	
12	Шар чавга	

Тухайн багцад санал болгож буй бүтээгдэхүүн нь горимын дагуу хадгалагдсан, эрүүл ахуйн шаардлага хангасан, бүтээгдэхүүн хадгалах зориулалтын зоорь хөргүүртэй байх.

**1. Тавигдах шаардлага, хяналт:** Бүтээгдэхүүний орц норм болон тендерийн шаардлага, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн явцад захиалагчийн зүгээс хэсэгчилсэн болон бүрэн хяналт шалгалтыг хийж байна. Бүтээгдэхүүн бүрийн үйлдвэрлэсэн хугацаа тодорхой, зориулалтын савлагаатай байна.

### 4-р багц: Гурил, гурилан бүтээгдэхүүн

№	Нэр төрөл	Тодорхойлолт ба гарал үүсэл
1	Гурил	I зэргийн, гарал үүсэл, шинжилгээний бичигтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан, стандартад нийцсэн байх, илчлэг сайтай, орон нутгийн дээд зэргийн цавуулагтай, хөөлт сайн, орон нутагт тарьж ургуулсан
	Бүхэл үрийн гурил	
2	Алтан тарианы гоймон \ширхэг\	Шинжилгээний бичигтэй сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, "Алтан тария" ХХК ны, илчлэг сайтай
3	Алтан тарианы гоймон \Зкг\	
4	Каш	Шинжилгээний бичигтэй, хятадаас бусад улсад үйлдвэрлэгдсэн
5	Орос гоймон	Шинжилгээний бичигтэй сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой
6	Цагаан будаа	Шинжилгээний бичигтэй сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, Солонгос, орос улсад үйлдвэрлэсэн.

7	Шар будаа	Шинжилгээний бичигтэй, хятадаас бусад улсад үйлдвэрлэгдсэн
8	Гурвалжин будаа	Шинжилгээний бичигтэй сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, монгол, орос улсад үйлдвэрлэсэн , илчлэг сайтай
9	Талх	Монгол улсад үйлдвэрлэсэн, хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэрийн бүтээгдэхүүн Шинжилгээний бичигтэй сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой
16	Шпагети гоймон	Шинжилгээний бичигтэй сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, орос улсад үйлдвэрлэсэн.
17	Хөц будаа	

Тухайн багцад тавигдах шаардлага: Эрүүл ахуй, ариун цэвэр, хүнсний бүтээгдэхүүний чанар, хадгалалтын шаардлагыг бүрэн хангасан, мэргэжлийн хяналтын газрын дүгнэлттэй байх. Элдэв хольц хоггүй , үнэр амтгүй шаардлага хангасан. Ут сав баглаа боодол бүрэн бүтэн. Ус чийг, хөгц үүсээгүй хадгалалтын горим алдагдаагүй эрүүл ахуйн шаардлага хангасан байх.

#### 5-р багц: Сүү, сүүн бүтээгдэхүүн

№	Нэр төрөл	Тодорхойлолт ба гарал үүсэл
1	Сүү	Цэвэр байгалийн гаралтай, малын шингэн түүхий сүү, шинжилгээний бичигтэй, шаардлага хангасан
2	Нойтон аарц	Сайн шахаж хийсэн, шар сүү бага,\ боз биш \шинжилгээний бичигтэй
3	Тараг	Цэвэр байгалийн гаралтай, шинжилгээний бичигтэй сав баглаа боодол нь стандартад нийцсэн

Үнийн саналыг тухайн үеийн зах зээлийн ханшид нийцүүлж улирал бүрээр ирүүлэх

Тендерт оролцогчийн нэр:.....

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга .....

Албан тушаал, нэр: .....

Хаяг: .....

ЖИЧ: Нийлүүлэх бараа нэг бүрийг жагсаан бичээд нэг бүрийн үнийг тодорхой тавьж өгнө.

#### 6-р багц: Төмс, хүнсний ногоо

№	Нэр төрөл	Тодорхойлолт ба гарал үүсэл
1	Төмс	
2	Байцаа	
3	Лууван	Эрүүл ахуйн шаардлага хангасан байх. Элдэв шавьж хорхой идээгүй байх. Хөлдөж муудсан, зөөлөрсөн гэх мэт хадгалалтын горим алдагдаагүй байх
4	Манжин	
5	Сонгино	
6	Чинжүү	
7	Брокли	
8	Сармис	
9	Хүрэн манжин	

Үнийн саналыг тухайн үеийн зах зээлийн ханшид нийцүүлж улирал бүрээр ирүүлэх

Тендерт оролцогчийн нэр:.....

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга .....

Албан тушаал, нэр: .....

Хаяг: .....

ЖИЧ: Нийлүүлэх бараа нэг бүрийг жагсаан бичээд нэг бүрийн үнийг тодорхой тавьж өгнө

Боловсрол соёл, шинжлэх ухааны яамны сайдын  
2006 оны 08сарын 23-ны 301 дугаар тоот тушаал  
**ДОТУУР БАЙРНЫ ХҮҮХДИЙН ХООЛ, ҮДИЙН ЦАЙ ХӨТӨЛБӨР**

### **Сургалтын менежер, эмчийн гүйцэтгэх үүрэг:**

- ✓ Талуудын гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих, гэрээг дүгнэж захиралд танилцуулах
- ✓ Дотуур байрны хүүхдийн хоолонд, эрүүл ахуйд хяналт тавих
- ✓ Гал тогооны ариун цэвэр, сурагч бүрийн гарыг угаалгаж буй эсэхэд хяналт тавих, хоол бэлтгэж буй ажилчдын хүнсний аюулгүй ажиллагааны горим мөрдөж буй эсэхэд хяналт тавих, гарсан зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулж ажиллах

### **Хориглох зүйл:**

- ✓ Давс болон хийжүүлсэн ундаа, хүнсний нэмэлтүүдийг аль болох хэрэглэхгүй байх
- ✓ Хүүхдэд олгох хүнсний бүтээгдэхүүн нь: Баов боорцог, печень, хачиртай талх зэрэг гурилан бүтээгдэхүүн, ундааны зүйлд сүүн бүтээгдэхүүн, ундаа, жимсний зүйл халуун цай зэрэг

### **Нэг. Дотуур байрны хүүхдийн хоолны үйл ажиллагааг сургууль дээр зохион байгуулах**

1. Хүнсний бүтээгдэхүүнийг гэрээт борлуулагчаар дамжуулах, хувь хүнээс худалдан авахыг хориглоно.
2. Хоолны цэсийг долоо хоног бүрээр сургуулийн эмч боловсруулж захирал батлана.
3. Хяналтыг комиссын бага ангийн эцэг эхийн зөвлөлийн дарга ахлана.
- 4 . Хоолны, болон хүнсний бүтээгдүүнээс өдөр бүр дээж авч хадгалан бүртгэл хөтлөнө.

### **Хоёр. Хоолны түүхий эд хүнсний бүтээгдэхүүнд тавих шаардлага**

1. Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан байх, гэрээт гүйцэтгэгчээс нийлүүлж байгаа нөхцөлд сав, баглаа, боодолтой, шошготой байх
2. Амин дэм эрдэс бодисоор баяжуулсан бүтээгдэхүүн байх

3. Бүтээгдэхүүнд итгэмжлэгдсэн шинжилгээний байгууллагаар дүгнэлт гаргуулсан байх

### **Гурав: Дотуур байрны хоолны цэс зохиоход тавигдах шаардлага**

4. Сурагчдын эрүүл мэнд, дур сонирхолд нийцсэн байх
5. Цэсэд орсон бүтээгдэхүүний нийц, зохицлыг зөв сонгосон байх
6. Нэг сурагчийн өдрийн 4000 төгрөгт багтсан байх
7. Амархан муудаж чанараа алддаг хүнсний бүтээгдэхүүнийг цэсэд оруулахгүй байх
8. Сүү цагаан идээ, жимс, жимсгэний шүүс, баяжуулсан гурилаар хийсэн хүнсийг оруулсан байх
9. Цэсэд байгаа хүнсний бүтээгдэхүүний сард ноогдох давтамжийг хоёроос гурав байхаар тооцох
10. Печень, бялуу, шоколад, чихэр зэрэг бүтээгдэхүүн хийжүүлсэн ундааг цэсэд оруулахгүй байх
11. Хүйтний улиралд халуун ундааны зүйлээр үйлчлэх/буцалгасан аарц/
12. Эклогийн цэвэр бүтээгдэхүүн болон амин дэм, эрдэс бодисоор баялаг бүтээгдэхүүнийг сонгох

### **Дөрөв. Гэрээт гүйцэтгэгчийн баримтлах шалгуурууд**

1. Хүнсний үйлдвэрлэл явуулах зөвшөөрөлтэй, улсын мэргэжлийн хяналтын газрын дүгнэлттэй байх
2. Сургуульд нийлүүлэхээр санал болгосон бүтээгдэхүүнийг эрүүл , аюулгүй байдлын шинжилгээнд бүрэн хамруулсан байх
3. Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу савлах, зөөж тээвэрлэх боломжтой байх
4. Хүнсний шинэ бүтээгдэхүүнээр үйлчлэх, хадгалалтын хэмийг баримтлах нөхцлийг бүрдүүлсэн байх

5. Бүтээгдэхүүнээ хугацаанд нь авч ирэх.

6. Гэрээний хэрэгжилтээс санхүүгийн хариуцлага хүлээх чадвартай байх

**Тав:: Сургуулийн эмчийн хийж гүйцэтгэх ажлууд:**

1. Талуудын гэрээний хэрэгжилтэд байнгийн хяналт тавих гэрээг дүгнэж захирлын дэргэдэх зөвлөлд танилцуулах

2. Шаардлага хангахгүй хүнсний бүтээгдэхүүнийг буцаах

3 .Хөтөлбөрт ажиллагсад эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан эсэх, хүнсний аюулгүй ажиллагааны горим мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих гарсан зөрчил дутагдлыг тухай бүр нь арилгуулах

**Зургаа:: Хяналтын комисс** 1. Хоол үйлчилгээнд сургуулийн бага ангийн эцэг эхийн зөвлөлийн даргаар ахлуулсан хяналтын комисс хяналт тавина

. 2. Хяналтын комиссоос хэлэлцэж баталсан хуваарийн дагуу үдийн цайны үйлчилгээний чанарт хяналт тавих чиглэлүүд

2.1 Олгож байгаа хүнсний бүтээгдэхүүн нь эрүүл ахуйн шаардлага хангасан эсэх

2.2 Гал тогооны ариун цэвэр, сурагчдын гарыг угаалгаж байгаа эсэх

2.3 Хүүхдийн дур сонирхол, эрүүл мэндэд тохирч байгаа эсэх

2.4 Цагтаа олгож байгаа эсэх

2.5 Дээж бүтээгдэхүүн авч байгаа эсэх

2.6 Хоол үйлчилгээнд хяналт тавьсан хяналтын комиссын гишүүд үр дүнг сургуулийн захиралд тухай бүрд нь танилцуулна.

3. Хоол үйлчилгээний талаар сургуулийн захиргаа улиралд нэг удаа эцэг эхэд танилцуулж санал бодлыг тусгана.

4. Сургуулийн захирал аймгийн боловсрол соёлын газраас дотуур байрны хүүхдийн хоол хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг улирал бүрийн эцэст гаргаж БСШУЯ-нд танилцуулна.

5. Дотуур байрны хүүхдийн хоол үйлчилгээг шаардлагын хэмжээнд зохион байгуулаагүй хүүхдийн эрх ашгийг хохироосон нь шалгалтаар нотлогдсон байгууллага, албан тушаалтыг Боловсролын тухай хууль, бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**Тендерт оролцогч заавал бүрдүүлэх баримт бичгүүд**

1. Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар Хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар бизнесийн ү/а-ны үндсэн чиглэл, хаяг тохирсон эсэх

2. Голлох ажилтны танилцуулга, мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар /хүнс үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэжил эзэмшсэнийг гэрчлэх баримт/

3. Компаний танилцуулга, ажлын туршлага

4. Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай лавлагаа тодорхойлолтыг тендерт авч ирүүлэх / эх хувь/

5. Ажлын байрны дүгнэлт, мэргэжлийн байгууллагаар гаргаж ирүүлэх

6. Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шинжилгээний дүгнэлтийн хуулбар

7. Хүнсний бүтээгдэхүүн агуулах байрны /зоорь/ гэрчилгээний хуулбар, түрээсийнх бол 2019 оны түрээсийн гэрээний хуулбар, зураг ирүүлэх

8. МХГ-аас сүүлийн 1 жилд / 2023 он/ тавьсан акт, дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлсэн тухай нотлох баримтыг ирүүлэх /мэргэжлийн хяналтын газраас акт, дүгнэлт, албан шаардлага авсан тендерт оролцогчид хамаарна/

9. Тендерт оролцогч үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх тухай, үнийн өсөлтөөс хамаарах эрсдлийг өөрөө хариуцах тухай албан бичгээр мэдэгдэл ирүүлэх

10. Үйлдвэрийн хүчин чадал /багаж тоног төхөөрөмжийн жагсаалт/

11. Стандарт хэмжилзүйн хэлтсийн баталгаажуулалтанд хамрагдаж тохирлын гэрчилгээ авсан байх / хугацаа дуусаагүй /

12. Бүтээгдэхүүний жагсаалт, жагсаалтанд орсон бүтээгдэхүүн тус бурийн орц, норм, өртөг

13. Ажилчдын эрүүл мэндийн байдлыг тодорхойлсон мэргэжлийн байгууллагын үзлэг, шинжилгээний бичиг ирүүлэх. 2024 он
14. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2023 оны жил эцсийн тайлан
15. Татварын бичиг

**Долоо. Жишиг маягт**

1. Үнийн саналын маягт (Захиалагч байгууллагын нэр)-ын -----захирал танаа
1. Бид (тендерт оролцогчийн нэр) дор дурдсан бүтээгдэхүүнийг (санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр) төгрөгөөр үнийн саналын бичиг баримтын дагуу(тоо) хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бүтээгдэхүүн нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасан баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгээ үүгээр батламжилж байна.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр -----

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг тамга -----

Албан тушаалын нэр:

Хаяг: